

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ГАРЧИГ

ОРШИЛ 2

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	24
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	25

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Талст дөл” ХХК-ний Дундговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших ашиглалтын MV-017291 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд “Хонгор-3 жоншны ордыг ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлан, АМГТГ-с батлагдсан уурхайн 2024 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан шинэ дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн 1 жилийн хугацаатай /2024 он/ хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нь нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж тэднээр хэлэлцүүлсний дараа, жил бүр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12-р сард багтаан БОАЖЯ-нд ирүүлсний дараа, дараа жилийн төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын хэмжээг батална.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: MV-017291 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд “Хонгор-3 жоншны ордыг ашиглах”

Төслийн зорилго: Жоншны ордыг ашиглах төслийн хүрээнд нөөцийг олборлон, бүтээгдэхүүнийг экспортлох, улс орон болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, ажлын шинэ байр бий болгох зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

“Талст Дөл” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011048033

Регистрийн дугаар: 5105439

Хаяг: Дорноговь аймаг, Даланжаргалан сум, “Кевин Инвест” ХХК-ийн үйлдвэр


Утас: 99096800

Төслийн байршил:

MV-017291 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хонгор-3”-ийн жоншны ордын талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 330км, Сайншанд хотоос баруун урагш 130 км, Даланжаргалан сумын төвөөс урагш 20 км, төмөр замын Айраг өртөөнөөс баруун тийш 28 км зайд оршино.

Хүснэгт 1. Төслийн байршлын координат

№	X	Y
1	108°58'44.67"E	45°47'24.61"N
2	108°57'51.67"E	45°47'24.61"N
3	108°57'51.67"E	45°48'36.62"N
4	108°58'44.67"E	45°48'36.62"N



Зураг 1. Ордын байршлын зураг

Ордыг ашиглах арга

Ордын уул техникийн нөхцөл, хүдрийн биетийн зузаан, хөрсний зузаан, лицензийн талбайд гадаад овоолго үүсэх орон зай, ерөмдлөгийн явцад ан цавын шүүрлийн ус илрээгүй бөгөөд өмнө нь ил аргаар дунджаар 17 м гүн олборлосон байсан зэргийг харгалзан үзэж ил аргаар үргэлжлүүлэн ашиглахаар сонголоо. 11-р бүлгийн орд учир В зэрэглэлийн нөөцөд тулгуурлан олборлолтод өртөх С зэргийн нөөцийг нэмэн тооцоог хийлээ. Хонгор-3 ордын нөөцийг аль болох бүрэн ашиглах зорилгоор захиалагч талд бэлэн байгаа тоног төхөөрөмж, уурхайн ордын өргөн болон ажлын хамгийн бага талбайгаас хамааран 506002 тн хүдэр олборлон, 75279 тонн хүдэр ашиглалт явуулсаны дараа үлдэхээр төсөлд тусгалаа. Үлдэгдэл 75279 тонн нь С зэрэглэлийн нөөц бөгөөд В нөөцөнд тулгуурлан нөөцийн тооцоог хийв. Хонгор-3-ийн биетүүдийн хайлуур жоншны ил уурхайн хил хязгаарыг нийт В зэрэглэлийн нөөцийг ашиглах хүрээнд дараах байдлаар явуулахаар тогтоов. Уурхайн дундаж гүн 70 м, урт 285 м, өргөн 166 м бөгөөд 2 ширхэг ил уурхай үүсэхээр байна.

Уурхайн жилийн хүчин чадал, уулын ажиллах горим

Уурхайн хүчин чадлыг захиалагчаас өгсөн техникийн даалгаварын дагуу жилд 100 мян.т жоншны хүдэр олборлоно. Уурхай нь 6-10 сард (жилд 126 хоног) ажиллана.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах хоног

Тодорхойлолт	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
Уурхайн ажиллах горим	Календарь хоног	Хоног	365
	Улирлын сул зогсолт	Хоног	219
	Давагдашгүй хүчин зүйл (сул зогсолт)	хон/жил	15
	Олон нийтийн амралтын өдөр	хон/жил	5
	Ажиллах хоног	хон/жил	126
	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг/ээлж	12
	Хоногт ажиллах ээлж	ээлж/хон	2
	Хоногт ажиллах цаг	цаг/хон	12
	Төлөвлөгөөт цаг	цаг/жил	3156

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Даланжаргалан сум Ардын хувьсгалын ялалтын дараахан нутгийн захиргаадыг байгуулахад Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуунд харьяалагдаж байгаад 1924 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн V тогтоолоор “Даланжаргалан сум” нэртэйгээр Боржигон Цэцэн вангийн хошууны нутаг "Элдэв" хэмээх газарт байгуулагджээ. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа Цомог хэмээх газарт суурьшсан байна. Тус сум 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т төвлөрдөг.

Даланжаргалан сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгжтэй, 2700 хүн амтай, 821 өрхтэй, 126,7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй ба сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар шинээр үүсэн хөгжиж байна. Сумын нутаг дэвсгэрээр Монгол орныг дамжин Ази Европ тивийг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг төдийгүй, их хөлийн газар юм.

Тус суманд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, 300 гаруй сурагчидтай 9 жилийн болон бага сургууль, эрүүл мэндийн төв, 150 гаруй хүүхэдтэй “Номт ирээдүй” цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн хэсэг, Сүгмэл эм эргэлтийн сан, Зэвсэгт хүчний 281-р байгууламж зэрэг төрийн байгууллагууд, болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, хайлуур жонш, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал элбэгтэй

2.2 Байгаль орчин

Уур амьсгал

Тус сум хүйтэн, хуурай урт өвөл, харьцангуй чийглэг богино зунтай эх газрын эрс тэс уур амьсгалтай, 7 дугаар сард дулааны дундаж хэм 25 градус, 12 дугаар сард 21 градус хүрч хүйтрэх ба хүйтний хугацаа 2 сар үргэлжилдэг, цаг уурын дорнодын мужид хамаардаг.

Урин дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал өсч хөгжих үе 120-130 хоног байх ба ургамал ургалтын үед 120-170 мм тунадас унадаг. Хур тунадасны жилийн дундаж 165 мм бөгөөд үүний 10 мм нь 11-3-р сард, 155 мм нь 4 -10 дугаар саруудад унадаг бол жилийн туршид гол төлөв баруунаас хүчтэй салхилах бөгөөд салхины хүч нь хавартаа /4-5-р сар/ ширүүсдэг, шороон шуурга болохын өмнө нар хүрээлэн бүдгэрч тэнгэр улбар шар өнгөтэй болдог.

Амьтан ургамал

Нутаг орны байгалийн онцлогоос шалтгаалан тус суманд 35 зүйл хөхтөн, 124 зүйлийн шувуу, 7 зүйл хэвлээр явагчид амьдардаг. Олон зүйлийн шавж, аалз, аалз хэлбэртэн, мөн бусад сээр нуруугүйтний зүйлүүд байдаг.

Ургамлын хувьд цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилно. Шарилжны төрлийн ургамлууд түгээмэл тохиолддог ба үүнээс хамгийн элбэг болох агиас шаргал шарилж, олон зүйлийн цэцэгт ургамлаар баялаг.

Тухайлбал: Цахилдаг, сараана, гоо юлт, 2 наст гол гэсэр, сэдэргэнэ, хонгорзул, сөөгөн эмгэн шилбэ, имт гичгэнэ, хатны шар цэцэг, баглуур, өргөст бутаргана, үлтэн могойн идээ, ногоон удвал, улаан бударгана зэрэг ургамлууд элбэг тохиолдох бөгөөд хуурайшилтай жилүүдэд өвслөг болон бутлаг ургамал нилээд тэсвэртэй ургадаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах зөвлөмжүүдийг өгч байна. Ашиглалт, хаалтын үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд хүртэл багасгаж ажиллах нь зүйтэй.

3.1 Агаарын тоосжилт

Тоосжилтыг бууруулах арга хэмжээ: Тээврийн замаас үүсэх тоосжилт хамгийн их байгаа тул үүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөв. Говийн бор хөрс нь элсэрцэр механик бүрэлдэхүүнтэй хөнгөн хөрс тул салхи, ус болон хүн, техникийн нөлөөнд маш эмзэг учраас тээврийн хөдөлгөөний нөлөөгөөр хөрсний жижиг хэсэг нунтагран тоосжилтийг бий болгоно.

Сайжруулсан зам барих

Сайжруулсан замын байгууламж нь автозамын тухай хууль болон дүрэм журам, норм хэмжээнд тохирсон байна. Уурхайн авто замын байгууламж, хучилт, замын өргөн налуу зэргийг ТЭЗҮ-д тусгасны дагуу хийнэ. Уурхайн байнгын авто зам дээр гулсалт, нурул болон хагарал үүсэхэд эрсдлээс сэргийлж тогтмол үзлэг, хяналтыг хийнэ. Замын тоосжилтыг багасгахын тулд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт хийн мөн шаардлагатай тохиолдолд зам талбайг ус хангамж, хэрэглээ хэсэгт заасны дагуу услана.

Усалгаа:

Замыг услах нь тоос дарах хамгийн энгийн арга юм. Энэхүү аргыг хэрэглэхэд замыг урьдчилан бэлтгэх шаардлагагүй бөгөөд ус шүршигч машинаар замын гадаргууг усалж норгоно. Зам усалгааны машин нь усны нөөцлүүр, шахуурга, ус шүршигч цорготой байна.

Зарим судалгааны дүнгээр 1 метр квадрат талбайд 0.6 л ус зарцуулан усалгааг хийсний дараа нийт тоосжилт 30 минутын турш 95%-иар буурч байсан бол усны хэмжээг нэмэгдүүлэн 2л/м3 болгоход 3-4 цагийн турш нийт тоосжилт 74% буурах боломжтойг тогтоосон байдаг. Гэхдээ усалгааны аргын тоосжилт бууруулах үр ашиг нь замын материал, замын хөдөлгөөний ачаалал, цаг агаарын нөхцөлөөс хамааран нэлээд хэлбэлзэлтэй байдаг.

Уурхайн замаас үүсэх тоосжилтыг бууруулахад шаардлагатай усны хэмжээг нормчилсон зөвлөмж материал байхгүй ч АНУБХА-н замаас үүсэх тоосонцрыг тооцох аргачлалд 0.254мм хур тунадастай өдөр тоосжилт үүсэхгүй гэх үзсэн байдаг. Замын усалгааны тохиромжтой давтамжийг тодорхойлоход тухайн бүс нутгийн цаг уурын нөхцөл, замын ачаалал, нэг удаагийн усалгаанд шаардагдах ус хэмжээ зэргийг харгалзан үзнэ.

Хүлэмжийн хийг бууруулах:

Уурхайн машин, механизмуудын дотоод шаталтат хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болж байна. Хүнд даацын машин, механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж жил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.

Ашиглалтын бус талбайд аль болох техник ажилуулж газар шороо хөндөхгүй байх, мөн дотоод тээврийн замаас гадна олон салаа зам үүсгэхгүй байх, тээвэрлэлтийн зам маршрутад хяналт тавьж, тэмдэгжүүлэлт хийж ажиллах шаардлагатай.

3.2 Гадаргын ус болон газар доорх усны нөөц хомсдол

Төслийн талбайн ойролцоох нуур тойрмын урсyg хамгаалах үүднээс жил бүр хог хаягдлыг цэвэрлэх, орон нутгийн захиргаатай хамтран хамгаалах арга хэмжээг авч ажиллах ингэснээр түүнээс ундаалдаг зэрлэг амьтад болон бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдэд ач тустай юм. Шаардлагатай тохиолдолд нуурын талбайн хэмжээг тооцоолох, усны химийн үзүүлэлтийг тодорхойлж болно.

1. Уурхайн ажилчдын 00, цайны газарт бохирын систем суурилуулж, ахуйн бохир усыг цэвэршүүлэх бохир ус ил задгай хаяхаас сэргийлэх
2. Усны зохистой хэрэглээний талаар ажилчдад сургалт явуулах
3. Холбогдох газрын зөвшөөрөлгүй гүний худаг өрөдмөх, ус ашиглахгүй байх
4. Усны тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсийн дэглэмийг зөрчихгүй байх
5. Манай улс ус намагтай газрыг хамгаалах олон улсын конвенцод нэгдэн орсон байдаг тул лицензийн талбайн нөлөөллийн бүс дэх (5-15 км) ус намагтай газрыг хөндөхгүй, шороогоор дарахгүй, хэвээр нь үлдээх шаардлагатай.
6. Усны ундаргыг дэмжих, хамгаалах арга хэмжээг нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд хийх.

3.3 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах

Уурхайн барилга байгууламжаар нийт 20 га талбай эвдрэлд өртөх бөгөөд төлөвлөлтийн бусаар хөрс халцгайрч эвдэрхээс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уурхайн тээврийн маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ тавих

Уурхайн дотоод тээврийн 30.2 км замд дараах тэмдэг тэмдэглэгээг үйл ажиллагаатай уялдуулан байршуулах, энэ нь хөрсний эвдрэлээс хамгаалах арга бөгөөд замын хөдөлгөөн болон салхины нөлөөгөөр тоосжилт үүсэхээс сэргийлнэ.


Анхааруулах тэмдэг (Тэгш биш зам-зорчих хэсгийн гадаргуугийн эвдрэл, гэмтэл, бартаа, донсолгоотой хэсэгт ойртож байгааг анхааруулна, хайрга үсэрнэ-тээврийн хэрэгслийн дугуйн доороос хайрга, чулуу шидэгдэж болзошгүй хэсэгт ойртож байгааг

анхааруулна, мал тууж гарах газар, ан амьтан -зэрлэг ан амьтан гарч ирж болзошгүй хэсэгт ойртож байгааг анхааруулна гэх мэт уурхайн үйл ажиллагааны онцлогтой уялдуулна)

Хориглох тэмдэг (орох хориотой -тээврийн хэрэгсэл тэмдгээс цааш орохыг хориглоно, хөдөлгөөн хориотой-тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно, мотоциклын хөдөлгөөн хориотой, ердийн хөсгийн хөдөлгөөн хориотой-ердийн хөсгөөр явах, мал туух болон хөтөлж явахыг хориглоно; явган зорчигчийн хөдөлгөөн хориотой гэх мэт уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хийх.)

Заах тэмдэг (чигээрээ явна, баруун гар тийш явна», зүүн гар тийш явна, чигээрээ буюу баруун гар тийш явна, чигээрээ буюу зүүн гар тийш явна, баруун буюу зүүн гар тийш явна-тухайн уулзвар, гарцыг зөвхөн сум заасан чигт нэвтрэхийг зөвшөөрнө. Зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн тэмдэг нь буцаж эргэхийг мөн зөвшөөрнө; Хурдны доод хязгаарлал-зөвхөн тэмдэгт заасан болон түүнээс илүү хурдтай (км/цаг) явахыг зөвшөөрнө гэх мэт уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хийх)

Мэдээлэх тэмдэг (Тууш зам-тууш замын хөдөлгөөний журмыг мөрдөх зам; Зүүнээс баруун гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй-хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг баруун гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй; Баруунаас зүүн гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй-хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг зүүн гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй гэх мэт уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хийх)



Зураг 2. Тээврийн маршрутын дагуу анхааруулах болон чиглэл заасан тэмдэглэгээ

Үржил шимт хөрсний овоолго үүсгэх, хадгалах

Эвдрэлд орох 20 га талбайн хөрсийг 0.2-0.3 м зузаантай хуулж тусад нь 3м-ээс ихгүй өндөртэй, 280 налуутай хураана. Шимт хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглах тул эвдэгдсэн талбайтай ойр хураана. Ашиглалтын жилүүдэд 21.3 мян.м³ шимт хөрсний овоолго үүсгэж хадгална. MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт стандартыг баримтлана.

Шимт хөрс хуулах, төлөвлөх, бэлтгэл ажил

Тухайн жил уурхайн нөлөөлөлд өртөж хуулагдах талбай, шимт хөрсний хэмжээ, олборлох шимэрхэг хөрсний хэмжээ болон байршуулах овоолгы болон овоолго үүсгэн байрлуулах талбайн байршил, хэмжээг уулын ажлын төлөвлөгөөнд тусгана.

Уурхайн нөлөөлөлд өртөх талбайд байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээг хийж, шимт хөрс хуулах зузааны хэмжээг тогтооно. Говийн бүсэд шимт хөрсийг 0-40 см хүртэл гүн хуулахаар тогтооно. Шимт хөрст талбайд хөрсний тодорхой гүнүүдээс дээж авч шинжлүүлэн хөрсний үржил шим, механик бүрэлдэхүүнийг тодорхойлон шаардлагатай бол чанарын хэсэгчилсэн зураг гарган боловсруулж батлуулна.

Шимт хөрсийг хадгалах

Шимт хөрсийг зөвхөн нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглана. Шимт хөрсний овоолгын зөвшөөрөгдөх хамгийн дээд өндөр нь 5 метр байна. Овоолгыг хэлбэршүүлэхдээ хотгор гадаргуугийн талбайг багасгахын тулд шимт хөрсний овоолгын хажуугийн налууг 15 градус, дээд гадаргын налууг 5 градусаас ихгүйгээр тэгшилнэ.

Гурван жилээс дээш хугацаанд хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэржүүлж олон наст өвслөг ургамал тарина.

Шимт хөрсийг хуулсан даруйд төлөвлөгдсөн талбайруу зөөж хадгална

Шимт хөрсийг овоолсон цагаас эхлүүлээд нөхөн сэргээлтэнд ашиглах хүртэл жил бүр чанарын болоод бохирдлын шинжилгээнд хамруулж, шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлэх ба газрын зураг дээр байршлийг нь тэмдэглэж мэдээллийн санд хадгална.

Хог хаягдлын зохицуулалт

Дорноговь аймгийн Даланжаргалан сумтай хог хаягдлын гэрээ байгуулан зайлуулах шаардлагатай бөгөөд хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйлд заасан дараах үүргийг биелүүлж ажиллана.

Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах;

Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;

Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх.

3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ

1. Ургамлын мониторинг арга хэмжээ

Уурхайгаас зүүн хойд зүгт 22 км замд сайжруулсан замаар (8 км засмал замаар нийт 30 км) баяжмал тээвэрлэлт хийгдэх тул сайжруулсан замын чиглэлд, замаас 2 тийш 200 м зайд жилд 1 удаа ургамал ургалтын хугацаанд мониторинг хийх

2. Уурхайн тосгоныг тохижуулах, ногоон байгууламж байгуулах зөвлөмж

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7.2.4-т заасны дагуу уурхайн эзэмшил талбайн 10% -д зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлнэ. Уурхайн төлөвлөлтөөр хөндөгдөхөөргүй газрыг сонгон ногоон байгууламжийг төлөвлөх нь зүйтэй. Говийн бүс нутаг нь салхи ихтэй байдаг тул уурхайн ачилт тээвэрлэлтээс тоос их үүсэх тул нөмөрлөх байдлаар салхин дээд талд бий болгох боломжтой хэдий ч үйл ажиллагаатайгаа уялдуулан гаргана.

3.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Уурхайн орчим 20-иод тооны аргаль нутагладаг тул өвлийн улиралд биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Уурхайн үйл ажиллагаа гол төлөв 4 сарын 01-нээс эхлэдэг ба энэ үе нь амьтан ичээнээс гарч идэвхтэй амьдарч эхлэх үетэй тохирдог. Хөрс хуулалтын ажил тус талбайд амьдрах жижиг мэрэгч амьтдын үржлийн үетэй давхцаж байгаа ба 4-р сард хөрс хуулалтаа багтаан хийвэл олонх амьтан 5-6-р сард төллөдөг тул тэдгээр амьтад төллөхөөс өмнө амжих тул амьтны хорогдлын тоо бага байх болно

Олон жилийн ажиглалтаар уурхайн хогийн цэгт үнэг, хярс, хүнд ойромсог шувууд ирж хооллодог болох нь ажиглагдсан тул хогийн цэгийг ариун цэврийн журмын дагуу байгуулж, амьтан муудсан хоол идэх, өвчлөхөөс сэргийлнэ.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго

Жоншны ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, түүнд зарцуулагдах зардлыг бодитой тооцоолох, байгаль орчны мониторинг хийхэд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгагдсан арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч шат дараалалтайгаар хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хамрах хүрээ

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгэм хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- Төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах,
- Төслийн хаалт нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг тусгах
- Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- БОМТ түүний хэрэгжилтэнд оролцогч талуудыг тодорхойлж, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох.

Хонгор-3 жоншны ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсвийг тодорхойлон 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанар									
1		Уурхайн замын усалгаа хийх,	Замын усалгаа,	м ³	ҮАЗ			Хуурайшилт их үед хугацаа харгалзахгүй	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль;
2	Утаа болон хийн бохирдол үүсэх	Машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, шаардлагатай тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх төхөөрөмж тавих	Гэмтэл гарсан тухай бүрт	ш	ҮАЗ				Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
		Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд дааацын машин механизм		ҮАЗ				
2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц									

3	Усны нөөц багасах, түвшин буурах	Уурхайн ойр орчмын булаг шандыг цэвэрлэх,	Нөлөөллийн бүсийн орчмын хог хаягдлыг цэвэрлэх,	1,000,000	1,000,000	2024 он	”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
3. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг							
5	Хөрсний элэгдэл, эвдрэл бий болох	Уурхайн үйл ажиллагаанд өртөхгүй газрыг хаалт хийж элэгдэл эвдрэлээс хамгаалах	Мал амьтан унаж болзошгүй газруудад шороон хаалт, хийж аюулыг эрсдэлийг бууруулах		ҮАЗ	2024	MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага” “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”
6		Тээврийн зорчих чиглэлд тэмдэг тэмдэглэгээ байршуулах (олон салаа зам гаргаж хөрс эвдэхгүй байх)	Чиглэл ш заасан 7ш, анхааруулах 2 ш		1,000,000		
7		Тээврийн маршрутын чиглэлд (22км) замаас 2 тийш 200м зайд ургамлын мониторинг хийх	Ургамал ургалтын хугацаанд 5-8 сард Жилд 1 удаа				
		Авто зогсоол, авто засварын газар болон ШТС-ийн орчмын	Төслийн талбайд		ҮАЗ	2024I он	

талбайг тос нэвчүүлэхгүй байхаар хайрган болон цементэн хучилттай болгох					
4.Амьтны аймаг					
8	Зэрлэг ан амьтан үргэн дайжих, идэш тэжээл	Уурхайн ухааш нүхт зэрлэг амьтан унаж үхэхээс урьдчилан сэргийлж хаалт хийх	(хөрс хамгаалах хэсэгт тусгасан)	ҮАЗ	(хөрс хамгаалах)
9	хомсдох, тоо толгой багасах	Уурхайн талбайд 20-иод тооны аргал өвөлждөг тул биотехникийн арга хэмжээ авах	Өвс, ус бэлтгэж идээшлэх газарт нь дөхүүлж тавих	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Өвлийн улиралд
		Хууль бус ангийн талаарх үйл ажиллагааны мэдээллийг холбогдох газруудад мэдээлж бүртгэлд авч ажиллах	Төслийн талбайд		
5.Нийгэм					
10	Малын бэлчээр хязгаарлагдах, бэлчээр талхлагдах, шуугиан үүсэх, амьдрах, тав тух алдагдах	Нөлөөллийн бүсийн нэг чиглэлдэх 5-6 айлын хөрзөнг хуулж өгөх		4,000,000	Жил бүр
Нийт				6,000,000	

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Хийхгүй						
2	Биологийн нөхөн сэргээлт	Хийхгүй						
3	Тэр бум мод хөтөлбөр	2-3 настай тарьц суулгацийг Даланжаргалан сумын Байгаль орчны байцаагчийн санал болгосон газарт тарих	ш	500	5000	ҮАЗ	2024 оны хавар намар	БОАЖС-ын А/172, 116-р тушаалын дагуу зардал нормыг тооцлоо. Ингэхдээ "Хээрийн бүсд нөхөн сэргээх, ойжуулах; Навчит модны тарьц"-аар мод тарихаар төлөвлөлөө.
4	Эдэлбэр газрын ногоон байгууламжийн хэмжээний 10%-д ногоон байгууламж байгуулах	Ажилчдын суурин орчимд мод ургамал тарих	га			ҮАЗ	2024	Газрын тухай хууль 56.6-д заалт
	Нийт							

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчин алдагдсан биологийн төрөл зүйлийг хамгаалах	Биотехникийн арга хэмжээ	Зэрлаг амьтдад өвс тэжээл,хужир бэлтгэх	10-50 боодол		5,000,000	Жил бүрийн өвөл хавар	
	Нийт					5,000,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хонгор-3 жоншны ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд айлын эзэмшил газар байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил хийх шаардлаггүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай түүний орчимд хамгаалах шаардлагатай соёлын дурсгалт зүйл байхгүй. Уурхайн ашиглалтын явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгааллах ажлыг зохион байгуулна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй осол, нөлөөлөл	аюул, сөрөг	Урьдчилан хамгаалах арга	сэргийлэх, хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах зүйн бичиг	эрх баримт
1.Галын аюулгүй байдал											
1.	Автомашин	зогсоол, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болозошгүй	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол, хүрз, элс, хөөс, аюулгүй байдлын самбар) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулаж, дууссан тохиолдолд цэнэглүүлэх				ХАБЭА-д төлөвлөгөөнд	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Галын аюулгүй байдлын тухай: Зүйл 16-1, 2; Зүйл 18-1, 2; Зүйл 19-1, 2; Зүйл 20-1, 2; Зүйл 21-1, 2, 3 Галын аюултай бодис. Материал ангилал. М№ 4284:95		
			Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж цайны газар, ажилчдын тамхины цэг болон бусад шаардлагатай гэсэн газарт байрлуулах				ХАБЭА-д төлөвлөгөөнд	Жил бүр			
			ШТМ-ын хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу хийж түүнтэй харьцан ажиллах ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулах				ХАБЭА-д төлөвлөгөөнд	Жил бүр			
2.Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл											

Хүчтэй салхи, шороон шуурганы үед харагдах орчин хязгаарлагдах ажил зогсох	Уурхайн ажилыг түр зогсоох, машин техникийг аюулгүй байдал хангасан газар зогсоож, уурхайн нуралт, гулсалтаас сэргийлэх арга хэмжээ авах, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх				ХАБЭА-д төлөвлөгөөнд	Жил бүр	Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 10-1.1; Зүйл8-1; Зүйл 13-2.5; Зүйл 34-1; Зүйл 34- 2
Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал алдагдах, дэд бүтцийн байгууламж болон уурхайн карьерт үер ус буух, ажилчид гэмтэж бэртэх	Уурхайн ажлыг түр зогсоох, усыг зайлуулах, соруулах суваг шуудуу татах, үерийн хамгаалалт хийх, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх				ХАБЭА-д төлөвлөгөөнд	Жил бүр	
3.Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл							
Уурхайн тоног төхөөрөмж саатах, эвдрэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх				ХАБЭА-д төлөвлөгөөнд		
Зам маршрут өөрчилж явснаас үүдэн осол гарах санамсаргүй хоорондоо мөргөлдөх	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах Замын тэмдэг тэмдэглэгээг				ХАБЭА-д төлөвлөгөөнд		

		сайжруулж байх, техник хэрэгсэлд яаралтай үед ашиглах хэрэгсэл, эмийн сан тогтмол байлгах						
	ШМТ-ын хадгалалт, хамгаалалт зөв хийгдээгүйгээс тэсэрч дэлбэрэх, ажилчид хордох, бэртэх	Аюулгүй байдлын талаар зөвлөмж өгөх анхааруулга тэмдэглэгээ хийх				ХАБЭА-д төлөвлөгөөнд		
	Нийт					ХАБЭА-д төлөвлөгөөнд		

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	СН-ийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах түр цэг байгуулах	Хог хаягдлыг салхиар хийсэхээс хамгаалсан байна. Хаягдлыг нэгдсэн цэгт нийлүүлэх гэрээ байгуулах, мэргэжлий байгууллагаар тээвэрлүүлэх Сум орон нутагтай хийсэн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний дагуу зохицуулна					2024	
		Хог хаягдлыг ангилан ялгах	Дахин ашиглагдах (хуванцар) -Дахин ашиглагдахгүй -Аюултай хог хаягдал					2024	
	Хог хаягдлын бүртгэл	Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын хэмжээг бүртгэхэд анхаарах, бүртгэл дэр үндэслэн хог хаягдлыг бууруулах боломжийг эрэлхийлэх						2024	
2.	Үйлдвэрийн	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнээс үүсэх хатуу хаягдал	Ашиглалтаас гарсан машин механизм гарах тохиолдолд, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдлыг, эрх бүхий байгууллагад шилжүүлэх					2024	

3.	Аюултай	Шатах тослох материалын хаягдал	Шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд хадгалж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх					2024	
	Нийт							5,000,000	

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
	Гэнэтийн ослын даатгалд хамруулах	Гэрээний дүнгээр	1 дүгээр улирал	Хүний нөөцийн мэргэжилтэн
	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх		2024	MNS 4219-94
	Нийт			

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	1.Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM2.5, PM10 Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: 8O _x , NO _x)..	Тээврийн замын салхин дээд болон доод талд уурхай орчим, замтай ойр айл өрхийн дэргэд	Жилд 2 удаа 5,8 сард Уурхайн тээврийн зам талбай болон уурхай орчимд тоосжилтын байдалд хэмжилт,	Жилд 2 удаа 5,8 сард				Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: МХ8 4585:2007 МН8:4048-88. Тоосны хэмжээг

			ажиглалт явуулж бүртгэл хөтлөх					тодорхойлох жингийн арга.
2.	Усны ерөнхий химийн шинжилгээ, рН, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃),ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Са, Мд, N3, К, 8O4, N02, N03, ^Щны агууламж, амт, үнэр, өнгө.	Сумын төвийн худгаас	жилд 2 удаа (5, 8 сард)*					Усны тухай хууль 2012.05.17 Ундны усны чанарын стандарт МК8 900:2018
3	Хөрсний химийн шинж чанар, Бохирдуулагч бодисын шинжилгээ хийлгэх	1.Уурхайн талбай (эвдрэлд орсон газар) зам дагуу, 2.кемп (хог хаягдлын цэгийн ойролцоо) 3. техникийн засвар үйлчилгээний газрын ойролцоо 4.хөндөгдөөгүй газарт	Жилд 2 удаа (5,8-р сард)*5 байршилд Химийн шинжилгээ Хүнд металл Эрүүл ахуй					MNS 5850 2019 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга MNS 5850 : 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Ургамлын зүйл, бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, үнэмлэхүй болон	Уурхайн талбай болон тээврийн замаас хоёр тийш 200 м зайд	Төсөл хэрэгжих хугацаанд (Y11/20- ноос YШ/20-ны хооронд буюу					Ургамлын хээрийн судалгааны геоботаникийн бичиглэл болон тэмдэглэл

	дундаж өндөр см, ургац ц/га		ургамлын масс цэцэглэлтийн үед) I,болон V жилд					
5	Туруутан амьтдын тоо толгой, шилжилт хөдөлгөөнийг тогтоох, тандалт хийх Шувуудын зүйлийн бүрдэл болон нягтшил, амьдрах орчны тандалт судалгааг хийх	Төслийн талбай орчимд болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран судалгааны ажлыг хийх					Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
	Нийт					3,000,000		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ
ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилт ан	Зохион байгуулах газар
	БОМТ-ний үр дүнг танилцуулах	Танилцуулга	Уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөлөл болон сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн, хяналт мониторингийн явцыг танилцуулна.	БИНХ-тай уядлуулан	1,000,000	ҮАМ БОМ	Багийн иргэдийн байранд
	Нийт				1,000,000		

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Урьдчилсан байдлаар тооцож үзэхэд 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт **20 000 000** төгрөг зарцуулах тооцоо гарч байна. Энэхүү хэмжээ нь тухайн жилээс хамааран өөрчлөгдөж болно.

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6,000,000
Дүйцүүлэн хамгаалалын төлөвлөгөө	5,000,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5,000,000
Оролцогч талуудад тайлагнах	1,000,000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,000,000
Нийт дүн	20,000,000

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.